

УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТОГТООХ ТАЛААР МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

1. Оршил

1.1 Энэхүү удирдамжийг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Урьдчилан сэргийлэх журамд нийцүүлэн гаргасан болно.

1.2 Энэхүү удирдамжийг улс төрд нөлөө бүхий этгээдийн хувьд харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиглана. Энэ удирдамж нь мэдээлэх үүрэгтэй этгээдийг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Урьдчилан сэргийлэх журмаар хүлээсэн аливаа үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

2. Товчлол, нэр томъёоны тайлбар

2.1 Өөрөөр заагаагүй бол тус удирдамж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Урьдчилан сэргийлэх журам дахь ижил үг хэллэг нь адил утгыг илэрхийлнэ. Үгийн товчлол, нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:

2.1.1 “МУТСТ хууль” - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;

2.1.2 “УСЖ” – Урьдчилан сэргийлэх журам;

2.1.3 “ЭӨ” – харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг; харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг; хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг хэлнэ;

2.1.4 "ХТМ" – Харилцагчийн таньж мэдэх үйл ажиллагаа;

2.1.5 "МҮЭ" – мэдээлэх үүрэгтэй этгээд;

2.1.6 “Ойрын хүрээний хүн” - УТНБЭ-тэй нийгмийн, хувь хүний, мэргэжлийн, аль эсвэл бизнесийн харилцаагаар нягт холбоотой хүн.

2.1.7 "Гэр бүлийн гишүүд" - УТНБЭ-тэй шууд эсвэл гэр бүлийн харилцаагаар нягт холбоотой хүмүүс. Үүнд:

2.1.7.1 эхнэр, нөхөр болон хамтран амьдрагч;

- 2.1.7.2 хүүхэд (үрчилж авсан, дагавар хүүхэд мөн багтана);
 - 2.1.7.3 төрсөн болон хойд эцэг, эх;
 - 2.1.7.4 эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн эцэг, эх;
 - 2.1.7.5 төрсөн болон хойд эцэг, эхийн хүүхэд.
- 2.1.8 “ФАТФ” - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага;
- 2.1.9 "СМА" – Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба;
- 2.1.10 " УТНБЭ" - улс төрд нөлөө бүхий этгээд;
- 2.1.11 "СГТ" – Сэжигтэй гүйлгээний тайлан.

3. Дотоод, гадаадын болон олон улсын байгууллагын УТНБЭ

- 3.1 Тухайн хүний оршин суугаа хаяг эсвэл иргэншил нь УТНБЭ-ийн төрлийг тогтооход хэрэг болно. Мөн дотоодын УТНБЭ-ийн эрсдлийн түвшинг тогтооход ч тустай зүйл юм.
- 3.2 Дараах хүмүүсийг дотоодын УТНБЭ гэж үзнэ. Үүнд:
- 3.2.1 Монгол Улсын ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайд нар;
 - 3.2.2 Дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, гүйцэтгэх болон хэрэгжүүлэгч агентлагийн дарга, дэд дарга нар;
 - 3.2.3 УИХ-ын гишүүд;
 - 3.2.4 Монголбанкны ерөнхийлөгч болон захирлуудын зөвлөлийн гишүүд, Хяналтын зөвлөлийн гишүүд; Санхүүгийн зохицуулах хорооны дарга, удирдлага;
 - 3.2.5 Үндсэн хуулийн цэц, Дээд болон бусад шүүхийн дарга, гишүүд, шүүгч нар;
 - 3.2.6 Ерөнхий прокурор, түүний орлогчид;
 - 3.2.7 Тагнуулын ерөнхий газрын дарга, түүний орлогчид;
 - 3.2.8 Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд нар;
 - 3.2.9 Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Хуурай замын зэвсэгт хүчин болон Агаарын цэргийн командлагчид, тэдгээрийн орлогчид;
 - 3.2.10 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын, прокурорын, тагнуулын байгууллагын дарга нар, давж заалдах шатны болон дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч болон шүүгч нар;
 - 3.2.11 Төрийн өмчийн, төсвийн байгууллагуудын, дүрмийн сангийн 50-с дээш хувийг төр эзэмшиж буй эдийн засгийн түншлэлийн захиргаа, удирдлага, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий нэгжүүдийн дарга нар;
 - 3.2.12 Улс төрийн намуудын удирдах зөвлөлийн дарга, намын төв аппаратын гишүүд;
 - 3.2.13 Засгийн газрын агентлагийн дарга;
 - 3.2.14 Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны бүрэн эзэмшилд буй компаний захирлууд.

- 3.3 Гадаадын УТНБЭ гэдэг нь энэхүү удирдамжийн 3.3-г заасантай адил чиг үүргийг хэрэгжүүлж буй гадаадын иргэдийг хэлнэ. Гадаадын УТНБЭ-ийн үүрэг функц нь энэхүү удирдамжийн 3.3-аар хязгаарлагдах албагүй.
- 3.4 Энэхүү удирдамжийн 3.3 дахь жагсаалт УТНБЭ-ийн цар хүрээг бүрэн хамраагүй болно. Иймд гадаад, дотоодын УТНБЭ-ийг тогтоох нь МҮЭ-ийн шууд үүрэг мөн.
- 3.5 Дараах иргэдийг олон улсын байгууллагын УТНБЭ гэж үзнэ. Үүнд:
- 3.5.1 Сүүлийн хэдэн жил олон улсын байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан/байгаа (тухайлбал, захирал, зөвлөлийн тэргүүн, тэдгээрийн орлогч нар) хүн;
 - 3.5.2 Удирдлагын бусад чиг үүргийг дээд түвшинд хэрэгжүүлж байгаа/байсан (ялангуяа олон улсын эсвэл засгийн газар хоорондын байгууллагад) хүн;
 - 3.5.3 Олон улсын парламентын ассамблейн гишүүд;
 - 3.5.4 Олон улсын шүүхийн шүүгчид болон удирдах албан тушаалтнууд.

4. УТНБЭ-ийн хувьд ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь

- 4.1 Харилцагч нь УТНБЭ мөн эсэхээс үл хамааран МҮЭ нь эрсдэлд суурилсан ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.2 Харилцагч нь УТНБЭ мөн тохиолдолд МҮЭ нь дараах нарийвчилсан ХТМ шалгуурыг хэрэгжүүлнэ:
- 4.2.1 харилцагч эсвэл ЭӨ нь УТНБЭ мөн эсэхийг тогтоох эрсдлийн удирдлагын системтэй байна;
 - 4.2.2 ийм бизнесийн харилцаа тогтоох буюу үргэлжлүүлэх аваас дээд түвшний удирдлагын зөвшөөрлийг бичгээр авна;
 - 4.2.3 хөрөнгө мөнгө, эд баялгийн эх үүсвэрийг тогтоох арга хэмжээ авна;
 - 4.2.3 бизнесийн харилцаанд нарийвчилсан хяналтыг тогтмол тавина.
- 4.3 Санхүүгийн байгууллага бүхий МҮЭ нь нөхөн төлбөр хийж буй тохиолдолд амь насны даатгалын ЭӨ нь буюу нөхөн олговор авагч этгээд нь УТНБЭ мөн эсэхийг тогтоох бүхий л арга хэмжээг авна.
- 4.4 Санхүүгийн байгууллага бүхий МҮЭ нь амь насны даатгалын ЭӨ буюу нөхөн олговор авах этгээд нь УТНБЭ байх магадлал өндөр гэж үзвэл дараах арга хэмжээ авна. Үүнд:
- 4.4.1 нөхөн олговор олгохоос өмнө энэ тухай дээд удирлагад мэдэгдэнэ;
 - 4.4.2 даатгуулагчтай тогтоосон бизнесийн харилцаанд нэг бүрчлэн дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол СГТ-аар мэдээлнэ.

4.5 МҮЭ нь харилцаагчдынхаа хувьд ХТМ үйл ажиллагааг зөвхөн бизнесийн харилцаа тогтооход төдийгүй харин тогтмол хэрэгжүүлснээр УТНБЭ мөн эсэх статуст байнгын хяналт тавина.

5. Харилцагч нь дотоодын УТНБЭ мөн эсэхийг тогтоох нь

5.1 Харилцагч буюу ЭӨ нь дотоодын УТНБЭ мөн эсэхийг тогтоохдоо МҮЭ нь УТНБЭ-ийн талаархи ХТМ мэдээлэл, нийтэд нээлттэй мэдээлэл, мэдээллийн сан, арилжааны мэдээллийг ашиглана. Энэхүү процедурыг МҮЭ нь дараах тохиолдолд хэрэгжүүлнэ:

- 5.1.1 бизнесийн харилцаа тогтоох үед;
- 5.1.2 хуульд заасан босго үзүүлэлтээс дээш дүнтэй гүйлгээ хийх үед;
- 5.1.3 хуульд заасан босго үзүүлэлтээс дээш дүнтэй хил дамнасан болон дотоодын цахим шилжүүлэг хийх үед;
- 5.1.4 мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлж байна гэх сэжиг төрсөн бол;
- 5.1.5 харилцагчийн талаар өмнө нь олж авсан мэдээлэлийн үнэн зөв, бодит байдалд эргэлзээ төрсөн бол.

5.2 МҮЭ нь УТНБЭ-ийг дотоодын хэмээн тогтоож буй тохиолдолд эрсдлийг бууруулах дараахь арга хэмжээ авч нарийвчилсан ХТМ үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

- 5.2.1 харилцагчийн талаар нэмэлт мэдээллийг (тухайлбал хөрөнгийн хэмжээ) олж авна;
- 5.2.2 харилцагч болон ЭӨ-ийн талаархи хувийн мэдээллийг өндөр давтамжтайгаар шинэчилнэ;
- 5.2.3 бизнесийн харилцааг чухам юунд ашиглахаар зэхэж буйг нарийвчилан магадлана;
- 5.2.4 хөрөнгө мөнгө, эд баялгийн эх үүсвэрийн талаарх мэдээллийг олж авна;
- 5.2.5 хийгдсэн эсвэл хийхээр зэхэж буй гүйлгээний шалтгааныг олж тодруулна;
- 5.2.6 бизнесийн харилцаа эхлэх эсвэл үргэлжлүүлэхийг дээд удирдлагаар шийдвэрлүүлнэ;
- 5.2.7 хяналтын механизмын тоо хэмжээ, хугацааг ахиулах замаар бизнесийн харилцаанд өргөтгөсөн хяналт тавина; цаашдаа шалгавал зохих гүйлгээний хэв шинжийг тогтооно.

5.3 МҮЭ нь УТНБЭ-ийн МУТС эрсдлийг үнэлж, нарийвчилсан ХТМ үйл ажиллагааг холбогдох эрсдлийн хүчин зүйлстэй нь уялдуулан хийж гүйцэтгэнэ.

6. Харилцагч нь гадаадын УТНБЭ мөн эсэхийг тогтоох нь

6.1 Харилцагч буюу ЭӨ нь гадаадын УТНБЭ мөн эсэхийг тогтоох үүднээс МҮЭ нь дотоод дүрэм журмынхаа хүрээнд эрсдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж дараахь арга хэмжээг авна. Үүнд:

- 6.1.1 харилцагчийг эрсдэлийн шалгуур, эрсдлийн зураглал болон бизнесийн загварт суурилан үнэлнэ;
- 6.1.2 ХТМ мэдээллийг шалгана;
- 6.1.3 МҮЭ нь харилцагч буюу ЭӨ-ийн талаар судалгаа хийнэ.

7. Харилцагч нь олон улсын байгууллагын УТНБЭ мөн эсэхийг тогтоох нь

7.1 Харилцагч эсвэл түүний ЭӨ нь олон улсын байгууллагын УТНБЭ мөн эсэхийг тогтоохдоо МҮЭ нь дотоодын УТНБЭ-эд тавих шалгуурыг ашиглана.

7.2 Дотоодын УТНБЭ-эд тавих шалгуурыг олон улсын байгууллагын УТНБЭ-ийн хувьд ч мөн ашиглана.

8. УТНБЭ-тэй бизнесийн харилцаа тогтоох буюу үргэлжлүүлэх

8.1 Бизнесийн харилцаа тогтоох буюу үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэхдээ МҮЭ нь:

- 8.1.1 тухайн УТНБЭ-тэй холбоотой МУТС эрсдэлийн түвшинг тогтооно;
- 8.1.2 МУТС эрсдлийг бууруулах хяналтын зохих механизмууд байгаа эсэхийг магадлана.

8.2 Бизнесийн харилцаа тогтоох буюу үргэлжлүүлэх шийдвэрийг дээд түвшний удирдлага гаргана.

8.3 МҮЭ нь бизнесийн харилцаан дахь гүйлгээ буюу үйл ажиллагаа нь хэвийн биш буюу сэжигтэй эсэхийг тогтоохын тулд бизнесийн харилцаанд тавих хяналтыг нэмэгдүүлнэ.

9. Гүйлгээ

9.1 МҮЭ нь УТНБЭ-д хамааралтай гүйлгээнд нарийвчилсан бөгөөд байнгын хяналт тавина.

10. Мэдээлэх

10.1 МҮЭ нь УТНБЭ-ийн хөрөнгө мөнгө нь гэмт хэргийн гаралтай хэмээн сэжиглэж байгаа бол СМА-нд СГТ-гаар мэдээлнэ.

10.2 СГТ-г МУТСТ хууль болон УСЖ-ын дагуу мэдээлнэ.

11. УТНБЭ-ийн бизнесийн харилцааны эрсдлийг үнэлэх нь

11.1 МҮЭ нь УТНБЭ-тэй үүсгэсэн бизнесийн харилцааны эрсдэлийг үнэлэхдээ боломжтой бүхий л мэдээллийг цуглуулах замаар УТНБЭ-ийн нийгэмд үзүүлж буй нөлөөллийг ойлгохыг хичээнэ.

11.2 Олон улсын байгууллагын УТНБЭ-ийн хувьд МҮЭ нь боломжтой бүхий л мэдээллийг цуглуулах замаар тухайн байгууллагын бизнесийн загварыг ойлгохыг хичээнэ. Бизнесийн харилцааг үнэлэхдээ дараахь зүйлийг харгалзан үзэж болох юм. Үүнд:

11.2.1 харилцагчийн эрсдэлийн хүчин зүйлс;

11.2.2 улс орны эрсдэлийн хүчин зүйлс;

11.2.3 бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ эсвэл хүргэлтийн сувгийн эрсдэлүүд;

11.2.4 УТНБЭ-ийн нийгэмд эзэлж байгаа/байсан байр суурины мөн чанар, тухайлбал хэр өндөр албан тушаал хашиж байгаа, улсын хөрөнгө мөнгөнд хэр ойр болон нөлөөлж чаддаг эсэх, албан тушаалын мөн чанар.

11.3 Эрсдэлтэй нөхцөл байдлын зарим жишээг Хавсралтад дурдав.

12. Эцсийн өмчлөгч

12.1 МҮЭ нь ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ ЭӨ-ийг шалгаж тогтоох арга хэмжээг авна. Үүнд ЭӨ буюу хяналтыг хэрэгжүүлэгч нь УТНБЭ эсвэл түүний гэр бүлийн гишүүн, ойрын хүрээний хүн байх хуулийн этгээд, тусгай зохицуулалттай хуулийн этгээд мөн багтана.

12.2 ЭӨ нь УТНБЭ гэж таамаглах хангалттай үндэслэл байгаа бол МҮЭ нь үүнийг шалгаж тогтооно.

12.3 МҮЭ нь тухайн хүн яагаад ЭӨ-ийг төлөөлөх болов гэдгийг магадлаж цаана нь буй ЭӨ нь УТНБЭ мөн эсэхийг тогтооно.

12.4 УТНБЭ-ийг төлөөлж буй хүн УТНБЭ-ийн гэр бүлийн гишүүн эсвэл ойрын хүрээний хүн байвал түүний хувьд УТНБЭ-д тавидаг бүх шалгуурыг нэгэн адил хэрэгжүүлнэ.

12.5 Амь насны даатгалтай холбоотой нөхөн олговрын төлбөрийг хийж буй МҮЭ нь эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж нөхөн олговрыг авч буй хүн нь УТНБЭ мөн эсэхийг тогтооно.

Жич: Даатгалын болон давхар даатгалын компаниуд болох МҮЭ-ийн хувьд УТНБЭ эсвэл түүний хамааралтай хүн нөхөн олговор хүртэх эцсийн харилцагч мөн эсэхийг тогтоож, хэрвээ тийм бол ХТМ үйл ажиллагааг хэрэгжүүлэх тусгайлсан заалтууд байвал зохино.

13. Нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэх нь

13.1 “Нийгэмд томоохон үүрэг гүйцэтгэж” буйг тодорхойлохдоо МҮЭ нь эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэнэ. Ингэхдээ тухайн УТНБЭ-ийн нийгмийн тодорхой чиг үүрэг хамаарах эрх мэдэл, үүрэг хариуцлага зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

14. УТНБЭ-ийн статусыг дуусгавар болгох эсэх

14.1 Нийгэмд томоохон үүрэг роль гүйцэтгэхээ больсон харилцагчтай харилцахдаа МҮЭ нь эрсдэлийн үнэлгээнд суурилагаас биш хугацааны хүчин зүйлд суурилахгүй.

14.2 Нийгэмд томоохон үүрэг роль гүйцэтгэхээ больсон УТНБЭ-ийн МУТС эрсдэлийг үнэлэхдээ МҮЭ нь дараахь хүчин зүйлсийг авч үзнэ. Үүнд:

14.2.1 тухайн хүний үзүүлж болох (албан бусаар) нөлөөллийн түвшин;

14.2.2 тухайн хүн УТНБЭ байхдаа хашиж байсан албан тушаал;

14.2.3 тухайн хүний өмнөх болон өнөөгийн чиг үүрэг харилцан хамааралтай эсэх (тухайлбал, УТНБЭ-ийн залгамжлагчаа зарлах, эсвэл УТНБЭ нь асуудлыг албан бусаар хариуцсан хэвээр байгаа эсэх).

15. Гэр бүлийн гишүүд, төрөл садан

15.1 УТНБЭ-ийн ойрын хүрээний хүн эсвэл гэр бүлийн гишүүдийн хувьд МҮЭ нь УТНБЭ-ийн шалгуурыг хэрэгжүүлнэ.

15.2 Тухайн хүн УТНБЭ-ийн гэр бүлийн гишүүн мөн эсэхийг тогтоохдоо МҮЭ нь тухайн хүний эрх мэдэл, гэр бүлийн гишүүд, хамааралтай хүмүүсийн хүрээг харгалзан үзнэ. Улмаар нийгмийн, эдийн засгийн, соёлын хүчин зүйлсийг авч үзэх замаар тухайн хүнийг гэр бүлийн гишүүн мөн эсэхийг тогтооно.

15.3 Тухайн хүн нь УТНБЭ-ийн ойрын хүрээний хүн мөн эсэхийг тогтоохдоо МҮЭ нь УТНБЭ болон тэр хүний хоорондох харилцаа хамаарлыг магадлана. Харилцаа хамаарал дараахь хэлбэртэй байж болно:

15.3.1 УТНБЭ болон тухайн хүн нь ижил улс төрийн нам, иргэний байгууллага, ажил олгочдын холбоо, үйлдвэрчний эвлэлд мөн харьяалагддаг;

15.3.2 УТНБЭ болон тухайн хүн нь бизнес түншүүд байх, ялангуяа нэг хуулийн этгээдийн ЭӨ-ид болдог бол, түүнчлэн компанийн ТУЗ болон бусад аргаар холбогддог бол;

15.3.3 УТНБЭ болон тухайн хүн нь гэр бүлээс гадуурхи харилцаатай секс хамтрагчид байх. Энэ тохиолдолд МҮЭ нь нийгмийн, эдийн засгийн, соёлын аспектыг авч үзэх замаар хэр ойрхон харилцаатай байгааг тогтооно.

15.4 МҮЭ нь эрсдэлийг үнэлэхийн тулд УНБЭ болон түүний ойрын хүрээний хүн, гэр бүлийн гишүүдийн харилцан хамаарлыг тогтооно.

15.5 Нийгэмд томоохон үүрэг роль гүйцэтгэхээ больсон УНБЭ-ийн ойрын хүрээний хүн эсвэл гэр бүлийн гишүүдийн хувьд УНБЭ-ийн шалгуурыг хэзээ хэрэгжүүлэхээ болихыг УНБЭ-ийн эрсдэлийн үнэлгээнд суурилан шийдвэрлэнэ.

16. УНБЭ-ийн талаархи мэдээллийн эх сурвалж

16.1 Харилцагч нь УНБЭ мөн болохыг тогтоох зорилгоор МҮЭ нь ХТМ үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлнэ.

16.2 МҮЭ нь ХТМ үйл ажиллагааг явуулахдаа харилцагчийн үндсэн ажил, албан тушаал, бизнесийн үндсэн чиглэлийг тогтооно.

16.3 МҮЭ нь мэдээллийг мөнгө угаахтай тэмцэх цахим хуудас; олон улсын байгууллагууд, ФАТФ болон бүс нутгийн байгууллагууд, ОУВС, Дэлхий банкны тайлан, үнэлгээнээс (тухайлбал, харилцан үнэлгээ); МУТСТ шаардлагын хангалт, засаглал, орлогын удирдлага болон ил тод байдлын дүн шинжилгээнээс; нээлттэй мэдээллийн эх сурвалж болон мэдээллийн сан; УНБЭ-ийн талаархи арилжааны мэдээллийн эх сурвалжаас эрж хайх боломжтой.

17. УНБЭ-ийн статуст өөрчлөлт орох нь

17.1 Харилцагч нь МҮЭ-тэй бизнесийн харилцаа тогтоосноос хойш УНБЭ болж статус нь өөрчлөгдсөн эсэхэд МҮЭ хяналт тавина.

17.2 МҮЭ нь харилцагчийн талаархи мэдээллийг тогтмол шинэчлэх ба мониторингийг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн үнэлгээнд суурилна.

18. Дотоод хяналтын бодлого

18.1 МҮЭ нь дотоод хяналтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ. Албан хаагчдаа сургах хөтөлбөр дотоод хяналтын бодлогын нэг хэсэг нь болно.

18.2 Сургалтын хөтөлбөрийн агуулга нь УНБЭ-ийг тогтоох, УНБЭ-тэй холбоотой эрсдэлийг ойлгох, үнэлэхэд чиглэгдэнэ.

19. Мэдээлэл хуваалцах

19.1 Солилцож буй мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах тогтолцоотой тохиолдолд санхүүгийн нэгдэлд багтах МҮЭ-үүд нь өөр хоорондоо УНБЭ-ийн талаархи мэдээллийг МУТСТ зорилгоор солилцож болно.

20. Дээд удирдлага

20.1 МҮЭ нь УТНБЭ-тэй бизнесийн харилцааг тогтоох, үргэлжлүүлэх зөвшөөрлийг дээд удирдлагаас авах шаардлагатай холбоотойгоор МҮЭ-ийн дээд удирдлага чухам хэн бэ гэдгийг тогтооно.

20.2 Дээд удирдлага нь хэн бэ гэдэг нь МҮЭ-ийн хэмжээ, бүтэц, мөн чанаараас хамаарна.

20.3 УТНБЭ-тэй харилцаатай байгааг МҮЭ-ийн дээд удирдлага мэдэж байх механизмтай байвал зохино. Дээд удирдлагын зүгээс зохих хяналт тавиагүй нөхцөлд МҮЭ нь УТНБЭ-тэй бизнесийн харилцаанд орохгүй байвал зохино.

20.4 УТНБЭ-тэй бизнесийн харилцаанд орох эсэхээ шийдвэрлэхдээ дээд удирдлага нь:

20.4.1 МҮЭ-ийн МУТСТ дотоод хяналтын хөтөлбөрийн талаар бүрэн мэдлэг, мэдээлэлтэй байвал зохино;

20.4.2 Хуучин болон шинэ харилцагчдын МУТСТ эрсдэлийн талаар сайтар ойлгосон байвал зохино;

20.4.3 МҮЭ-ийн МУТСТ бодлого, үйл ажиллагааг батлах үйл явцад идэвхтэй оролцож байвал зохино.

20.5 МҮЭ-ийн зүгээс дээд удирдлагаа чухам яаж тодорхойлж байгаагаас үл хамааран МҮЭ нь хяналтын хороо буюу түүнтэй төстэй шийдвэр гаргах бүтэцтэй байж болох ба тэр нь:

20.5.1 УТНБЭ-тэй бизнесийн харилцаа тогтоох эхний болон дараа дараагийн шатанд хяналт тавина;

20.5.2 тусгай тохиолдолд бүх дотоод мэдээллийг ашиглах боломжийг бүрдүүлнэ;

20.5.3 шаардлагатай тохиолдолд УТНБЭ-тэй бизнесийн харилцааг дуусгавар болгох үйл явцыг удирдана;

20.5.4 шаардлагатай бүхий л мэдээллийг (УТНБЭ-тэй холбоотой дотоод бодлого, үйл явц, хяналт) бэлэн байлгана.

21. Хөрөнгө мөнгө, баялгийн эх үүсвэр

21.1 МҮЭ нь УТНБЭ-ийн хөрөнгө мөнгөний эх үүсвэрийг тогтоох бүхий л арга хэмжээг авна.

21.2 Хөрөнгө мөнгөний эх үүсвэр гэдэг нь бизнес харилцааг (эсвэл МҮЭ болон УТНБЭ-ийн хоорондох ганц нэг удаагийн хэлцлийн) бүрдүүлж буй хөрөнгө эсвэл бусад активын эх үүсвэрийг, тухайлбал бизнесийн харилцааны хүрээнд хөрөнгө оруулсан, хадгалуулсан, шилжүүлсэн дүнг хэлнэ.

21.3 МҮЭ нь УТНБЭ-ийн эд баялгийн эх үүсвэрийг тогтоох бүхий л арга хэмжээг авна.

21.4 Эд баялгийн эх үүсвэр гэдэг нь УТНБЭ-ийн эд баялаг эсвэл нийт активын хэмжээг хэлнэ. Үүнд УТНБЭ-ийн хуримтлуулсан баялгийн хүлээгдэж буй хэмжээ болон УТНБЭ нь ийм баялгийг хэрхэн бий болгосон нь мөн хамаарна.

21.5 МҮЭ нь УТНБЭ-тэй тогтоосон бизнес харилцаанд ХТМ үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх замаар хийгдэж буй гүйлгээнүүд нь МҮЭ-ийн УТНБЭ-ийн хөрөнгө мөнгө, эд баялгийн эх үүсвэрийн талаархи ойлголттой нийцтэй байгааг баталгаажуулна.

21.6 МҮЭ нь дараахь зүйлсийг харгалзан үзэх замаар бизнесийн харилцаа нь УТНБЭ-ээс хүлээгдэж буй зүйлстэй нийцтэй байгааг баталгаажуулна:

21.6.1 УТНБЭ-ийн өнөөгийн орлого;

21.6.2 хөрөнгө мөнгөний эх үүсвэр;

21.6.3 эд баялгийн эх үүсвэр;

21.6.4 эрхэлж буй бизнес;

21.6.5 гэр бүлийн бизнес.

21.7 Бизнесийн харилцаа нь УТНБЭ-ийн хөрөнгө мөнгө, эд баялгийн эх үүсвэрийн талаархи ойлголтоос зөрүүтэй байвал МҮЭ нь бизнесийн харилцааг үнэлэх дараахь арга хэмжээ авна:

21.7.1 бизнесийн харилцааг үргэлжлүүлэх эсвэл дуусгавар болгох;

21.7.2 СМА-нд СГТ хүргүүлэх.

21.8 УТНБЭ-ийн хөрөнгө мөнгө, эд баялгийн эх үүсвэрийг магадлахдаа төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжийг, тухайлбал нийтийн өмчийн бүртгэл, газрын бүртгэл, хөрөнгө мэдүүлэх бүртгэл, өмнө нь хийгдсэн хэлцлүүд, эцсийн болон хууль ёны өмчлөгчийн мэдээлэл зэргийг ашиглана.

21.9 МҮЭ нь УТНБЭ-ийн хөрөнгө мөнгө, эд баялгийн эх үүсвэрийг тогтоохдоо тайлбарлаж болох эх үүсвэрийг хүлээгдэж байсан үзүүлэлттэй нь харьцуулах байдлаар гүйцэтгэнэ.

ЭРСДЛТЭЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ЗАРИМ ЖИШЭЭ**1. Харилцагчийн эрсдэлтэй холбоотой хүчин зүйлс**

- (a) бизнесийн харилцааг ердийн бус нөхцөл байдалд хэрэгжүүлэх (жишээ нь: УТНБЭ болон МҮЭ-ийн хооронд газар зүйн том орон зай байх);
- (b) байнгын оршин суугч биш УТНБЭ;
- (c) УТНБЭ нь өөрийн хувийн хөрөнгийн механизм бүхий хуулийн этгээд эсвэл тусгай зохицуулалттай хуулийн этгээдийг үүсгэн байгуулах;
- (d) нэрлэсэн хувьцаа эзэмшигчтэй эсвэл эзэмшигчгүй хувьцаа (shares in bearer form) бүхий компанид хяналт хэрэгжүүлж буй УТНБЭ;
- (e) УТНБЭ-ийг нуун дарагдуулах зорилгоор зуучлагчдыг ашиглах, бизнест онцын шаардлагагүй зуучлагчдыг ашиглах;
- (f) гэр бүлийн эсвэл ойрын хүрээний хүнийг хууль ёсны эзэмшигч болгон ашиглах;
- (g) УТНБЭ нь бэлэн мөнгө эргэлддэг бизнесийн үйл ажиллагаанд оролцох;
- (h) тухайн байгууллагын мөнгө угаахтай тэмцэх бодлого эсвэл УТНБЭ-ийн талаар баримталж буй бодлогыг асууж сонирхож буй УТНБЭ;
- (i) хөрөнгө мөнгө, эд баялгийг нь лавлахад эмзэг хандаж буй УТНБЭ;
- (j) УТНБЭ-ийн өгч буй мэдээлэл нь нийтэд нээлттэй байгаа мэдээллээс зөрөх;
- (k) УТНБЭ нь хамаарал байхааргүй улс орон руу эсвэл улс орноос байн байн хөрөнгө мөнгө шилжүүлэх;
- (l) иргэд нь гадаадад данс, өмч эзэмших хориотой улс орны УТНБЭ;
- (m) бодит бус, бүрэн бус мэдээлэл өгч буй УТНБЭ;
- (n) төрийн өмчийн хөрөнгө мөнгөнд ойр, эрх мэдлээ хэрэгжүүлэх боломжтой УТНБЭ;
- (o) тусгай зөвшөөрөл, лиценз, концесс олгох үйл явцад нөлөөлж чадах, хянаж чадах УТНБЭ;
- (p) нийгэмд эзэлж буй байр суурь, ач холбогдлоо “гийм биш” хэмээн бууруулж буй УТНБЭ;
- (q) засгийн газар эсвэл компаний тайлан дансанд ойрхон, хяналт, нөлөөгөө хэрэгжүүлдэг УТНБЭ;
- (r) УТНБЭ-тэй хамааралтай компаний бизнесийнх нь мөн чанар энгийн хэрнээ компаний өмчлөлийн бүтэц нь хэт төвөгтэй.

2. Улс орны эрсдлийн хүчин зүйл

- (a) харилцан үнэлгээний тайлан, дэлгэрэнгүй үнэлгээний тайлан, явцын тайлан, ФАТФ-ын цахим хуудас зэргээр МУТСТ тогтолцоо нь доголдолтой хэмээн тодорхойлогдсон улс орны УТНБЭ;
- (b) хориг арга хэмжээ авагдсан улс орны УТНБЭ;
- (c) авлига, хар тамхи, хүний наймаа, бусад гэмт хэрэг нэлээдгүй тархсан улс орны УТНБЭ;
- (d) өндөр эрсдэлтэй улс орны МУТСТ тогтолцоонд буй доголдол, сул талыг засч залруулах буюу шийдвэр гаргалтад нөлөөлж чадах УТНБЭ;
- (e) авлигын эсрэг гэрээ хэлцэлд нэгдээгүй, соёрхон батлаагүй, аль эсвэл хангалтгүй түвшинд хэрэгжүүлж буй улс орны УТНБЭ;
- (f) хууль бус экспортоос (тухайлбал, хар тамхины) хамааралтай улс орны УТНБЭ;
- (g) хувь хүний дарангуйлал, автократ дэглэмтэй улс орны, эсвэл эрх мэдэлтэй хүмүүс баяждаг, албан тушаалын томилгоог өөрийн эрх ашигт нийцүүлэн хийдэг улс орны УТНБЭ;
- (h) муу засаглалтай улс орны УТНБЭ;
- (i) террорист үйл ажиллагааг дэмждэг, санхүүжүүлдэг аль эсвэл террорист хэмээн бүртгэгдсэн байгууллагууд бүхий улс орон, бүс нутгийн УТНБЭ.

3. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, гүйлгээ эсвэл хүргэлтийн сувагтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлс:

- (a) хувийн банкинд оролцоотой УТНБЭ;
- (b) УТНБЭ-тэй нэр усгүй гүйлгээ хийх (үүнд бэлэн мөнгө мөн орно);
- (c) УТНБЭ-тэй нүүр тулалгүй хийх бизнесийн харилцаа, гүйлгээ;
- (d) зэвсгийн наймаанд оролцдог УТНБЭ;
- (e) засгийн газрын ханган нийлүүлэлттэй холбоотой бизнес;
- (f) барилга болон томоохон дэд бүтэц;
- (g) уул уурхайд оролцдог УТНБЭ;
- (h) УТНБЭ-ийн талаар тайлагнасан олон тооны СГТ;
- (i) хүлээгдэж буй бизнестэй нь холбон тайлбарлах боломжгүй, байнга хийгдэх бүхэл дүнтэй гүйлгээнүүд;
- (j) хувийн болон бизнесийн мөнгөн урсгалыг өөр хооронд нь ялгаж салгах боломжгүй байх;
- (k) санхүүгийн үйл ажиллагаа нь хууль ёсны аль эсвэл хүлээгдэж буй үйл ажиллагаатай нийцгүй, бизнесийн үндэслэггүйгээр хөрөнгө мөнгийг данснаас данс руу буюу аль эсвэл МҮЭ-үүдийн хооронд шилжүүлэх;

- (l) дансны томоохон хөдөлгөөн нь богино хугацаанд, аль эсвэл бизнес эхлэнгүүт гарсан, эсвэл удаан хугацааны туршид идэвхгүй байсан дансан дээр гарсан;
- (m) олон улсын хөрөнгө мөнгийг “тоглоомын данс” /smurf or gaming account/ руу хүлээн авч буй УТНБЭ. УТНБЭ нь “тоглоомын” зорилгоор бага хэмжээний мөнгийг данснаас татах ба ингэхдээ чек хэрэглэнэ;
- (n) тодорхой зорилгогүйгээр олон данс ашиглаж буй УТНБЭ;
- (o) УТНБЭ-ийн данснаас/данс руу хийсэн цахим шилжүүлгийг эдийн засгийн хувьд тайлбарлах боломжгүй, аль эсвэл шилжүүлэгч буюу хүлээн авагчийн талаархи мэдээлэл хангалтгүй;
- (p) үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэлж буй УТНБЭ;
- (q) тансаг тээврийн хэрэгслийн (автомашин, нисдэг тэрэг, онгоц) үйлчилгээ эрхэлж буй УТНБЭ;
- (r) УТНБЭ-тэй холбоогүй эсвэл үл таних гуравдагч этгээдээс хүлээн авсан төлбөр.